

НИЙСЛЭЛИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР
ЗАХИРАМЖЛАЛЫН БАРИМТ БИЧГИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

1. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ

2017 оны 12 дугаар сарын 12-ны өдөр

№	Эрх зүйн актын нэр, он, сар, дугаар	Зүйл заалтын дугаар, агуулга	Хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилт, үр дүн	Хувь	Үр нөлөө
1	Хурдан морний бүсийн уралдааны 2017 оны хуваарийг тогтоох тухай 2017.02.22 №63	2. Зуны Зүүн бүсийн хурдан морины уралдааныг Сүхбаатар аймагт, Хойд бүсийн хурдан морины уралдааныг Сэлэнгэ аймагт, Говийн бүсийн хурдан морины уралдааныг Дундговь аймагт, Хангайн бүсийн хурдан морины уралдааныг Өвөрхангай аймагт, Баруун бүсийн хурдан морины уралдааныг Увс аймагт, Төвийн бүсийн хурдан морины уралдааныг Улаанбаатар хот, Хүй долоон худагт 2017 оны 7 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж явуулсугай. 3. Хурдан морины уралдааныг тогтоосон хугацаанд холбогдох дүрмийн дагуу зохион байгуулалтын өндөр түвшинд, уралдаанч хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангасны үндсэн дээр явуулахыг холбогдох аймаг болон нийслэлийн Засаг дарга, Монголын морин спорт, уяачдын холбоонд тус тус даалгасугай.	Төвийн бүсийн хурдан морины уралдааныг Улаанбаатар хот, Хүй долоон худагт зохион байгуулах	Бүсийн уралдаан нь морин спорт уяачдын холбооноос зохион байгуулдаг. НХХААГ-аас комисст гишүүн байхгүй болно.	0 - хасах	Хурдан морины уралдааныг тогтоосон хугацаанд зохион байгуулагдана.
2	Үндэсний аян өрнүүлэх тухай 2016.12.28 №212	1. Үндэсний хэмжээнд зохион байгуулагдах “Мах, сүүний анхдугаар аян”-ыг шинээр эхлүүлж, “Атрын-III аян”-ыг үргэлжлүүлэх үйл ажиллагааг 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн улс даяар өрнүүлсүгэй.	“Мах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн хүн амын хэрэгцээнд зориулан мах борлуулах, сүү, сүүн бүтээгдэхүүний ач тусыг иргэдэд таниулах, сүүний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана.	Мах, сүүний анхдугаар аяныг угтаж “Сүү, сүүн бүтээгдэхүүний зохистой хэрэглээ”, “Монгол улсын сүүний салбарын хөгжлийн чиглэл” сэдэвт 50 гаруй төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлгээр Азийн сүү үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийн 10 зорилттой уялдуулан, хөгжлийн 6 чиглэлийг тодорхойлсон. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгчдэд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэх зорилгоор REACH төсөлтэй хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлж, сургалтад 3 аж ахуйн	100	Махны үнийг тогтворжуулж, хонины мах 1200 төгрөг буюу 22%, үхрийн мах 1635 төгрөг буюу 28.4%, ямааны мах 375 төгрөг буюу 8.5%-иар бага үнэтэйгээр борлуулж, сүүний ач тусыг иргэдэд

			<p>нэгжийг хамруулсан. Дэлхийн сүүний өдрийг угтан “Ирээдүйгээ сүүгээр мялаа” уриан дор 06 дугаар сарын 01-ний өдөр үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүг 10000 хүүхдэд бэлэглэх ажлыг зохион байгуулсан.</p> <p>“Мах сүүний анхдугаар аян”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын 14 дүгээр тогтоолын дагуу 12 аж ахуйн нэгж 15000 тн мах бэлтгэн, нийслэлийн 6 дүүргийн 130 гаруй дэлгүүрт 04-06 дугаар саруудад худалдаалсан. Ажлын хэсэг 12 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, гэрээг дүгнэж, дүн мэдээг удирдлагуудад танилцуулсан.</p> <p>ХХААХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А/457 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэгт орж ажиллан, орон нутгийн малчдаас мал, мах бэлтгэх зорилгоор арилжааны банкнаас олгох хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлт ирүүлсэн 33 аж ахуйн нэгжийн материалтай танилцан, шаардлага хангасан 23 аж ахуйн нэгжийн материалыг банкинд хүргүүлсэн.</p> <p>“Атрын III” аяныг үргэлжлүүлэх, “жимс жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийн хүрээнд ХХААХҮЯ-аас хүлэмжийн аж ахуй эхлэгчдийг дэмжих зорилгоор зээлийн хүлэмж олгосон ба энэхүү ажлын хүрээнд 32м2 талбай бүхий хүлэмж 27 ширхэг, 120м2 талбай бүхий хүлэмж 39 ширхэгийг ТЭДС-аас нийслэлийн иргэд авахад дэмжиж ажилласан. Налайх дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсэрт 15 га газрыг Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын эзэмшилд авч үүнээс 3 га талбайд өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулахад хамтран ажиллах зорилгоор “Сити Агро” ХХК-тай “Санамж бичиг” байгуулан ажиллаж</p>	<p>таниулан, хэрэглээг нэмэгдүүлж, Нэмүү Өртгийн сүлжээнд оролцогч талуудын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.</p>
--	--	--	---	---

				байна.		
		3. “Мах, сүүний анхдугаар аян” болон “Атрын-III аян”-ыг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөв, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгаж, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар шийдвэрлэж байхыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгаж, аяны хүрээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг холбогдох хууль тогтоомж, өөрийн хөрөнгө, өрийн удирдлагад нийцүүлэн санхүүжүүлэхийг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Даажамба), Төрийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Нямаа)-д зөвшөөрсүгэй. /Энэ заалтыг ЗГ-ын 2017 оны 108-р тогтоолоор өөрчлөн найруулсан/	“Мах, сүүний анхдугаар аян” болон “Атрын-III аян”-ыг зохион байгуулахад шаардагдах төсөвийн санал хүргүүлэх	“Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2017 оны төсвийн тодотгол болон Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2018 оны хөрөнгө оруулалтад шаардлагатай санхүүжилтийг тусгахаар саналыг хүргүүлсэн боловч батлагдаагүй.	30	“Мах, сүүний анхдугаар аян” болон “Атрын-III аян” зохих түвшинд хэрэгжинэ.
		4. “Мах, сүүний анхдугаар аян” болон “Атрын-III аян”-ыг харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг орон нутгийн онцлогт тохируулан баталж, хэрэгжилтийг зохион байгуулан явц, үр дүнгийн тайланг жил бүрийн 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, дүнг нэгтгэн улсын хэмжээний тайланг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэнд тус тус үүрэг болгосугай.	“Мах, сүүний анхдугаар аян” болон “Атрын-III аян”-ыг харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө орон нутгийн онцлогт тохируулан батлуулах	“Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан Нийслэлийн хэмжээнд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг орон нутгийн онцлогт тохируулан боловсруулсан.	30	Батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг зохион байгуулж хяналт тавина.
ДУНДАЖ ХЭРЭГЖИЛТ					53 %	
		1. “Улсын аварга малчин шалгаруулах журам”-ыг 1 дүгээр, “Улсын аварга фермер шалгаруулах журам”-ыг 2 дугаар, “Улсын аварга саальчин шалгаруулах журам”-ыг 3 дугаар, “Улсын аварга тариаланч хамт олон, Улсын аварга тариаланч шалгаруулах	Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнд Засаг даргын	Улсын аварга фермерээр Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны сүүний үхрийн фермер эрхлэгч Л.Алтангэрэл, Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны шувууны аж ахуй эрхлэгч Т.Далантай нар, Алтан төлийн	100	Аж ахуй эрхлэгч нарыг урамшуулж, нийгэмд сурталчлан таниулна.

3	<p>Журам батлах тухай</p> <p>2016.12.21</p> <p>№202</p>	<p>журам"-ыг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.</p> <p>2. Улсын аварга малчин, улсын хошой аварга малчин, улсын аварга фермер, улсын аварга саальчин, улсын аварга тариаланч хамт олон, улсын аварга тариаланчийг шагнахад шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт даалгасугай.</p> <p>3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан харьяа нутаг дэвсгэртээ малчдыг малын чанар, ашиг шимийн үзүүлэлт, тэдний нийгэмд үзүүлж байгаа хувь нэмэр, бэлчээр ашиглалт, хөрсний үржил шимийг хамгаалсан зэрэг шалгуурыг харгалзан шалгаруулж шагнаж урамшуулж байхыг аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.</p>	<p>удирдлагын зөвлөлийн тэмдэглэл болон бусад материалын хамт хүргүүлэх</p>	<p>эзнээр Багануур дүүргийн 1 дүгээр хорооны малчин Ж.Баттулга шалгарлаа.</p> <p>Нийслэлийн тэргүүний фермерийн болзлыг хангасан Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны фермер Н.Цэрэндаваа, Ш.Шүрэнцэцэг, 32 дугаар хорооны фермер Ш.Мөнхтулга,Ц.Баттулга, Хан-Уул дүүргийн12 дугаар хорооны фермер Ж.Нацаг, Багануур дүүргийн фермер Д.Пунцагдаш нарыг, Нийслэлийн сайн малчны болзол хангасан Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны малчин Ц.Цэдэвсүрэн, Багануур дүүргийн 5 дугаар хорооны малчин С.Сономноржин, Багахангай дүүргийн 1 дүгээр хорооны малчин Т.Отгонбаяр нарыг тус тус шалгаруулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 02 дугаар сарын 15 ны өдрийн 23 дугаар тогтоол, Засаг даргын А/99 дүгээр захирамжаар шагналыг шийдвэрлүүлж сар шинийн баярын өмнө шагнаж урамшуулав.</p>		
4	<p>Хөдөө аж ахуйн салбарын 2017 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай</p> <p>2017.06.28</p> <p>№186</p>	<p>1. Ихэнх нутгаар гандуу байгаатай холбогдуулан зун, намрын отор нүүдэл хийх, малын хөдөлгөөнийг хянах постыг нэмэгдүүлж, царцааны нүүдэлтэй тэмцэх, малчдад нийгэм, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, хадлан бэлтгэж аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг Засгийн газрын нөөц сангаас 1 дүгээр хавсралт ёсоор гаргаж, аймгуудын Засаг даргын Тамгын газарт олгохыг Сангийн сайд Б.Чойжилсүрэнд зөвшөөрсүгэй.</p>	<p>Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах талаар нийслэлийн Засаг даргын албан даалгаврын төсөл, боловсруулж батлуулах.</p>	<p>Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах талаар Нийслэлийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 04 тоот 2 зүйл 8 заалттай албан даалгаврыг дүүргүүдэд хүргүүлэн биелэлтэд нь хяналт тавьж ажилласан. Нийслэлийн Засаг даргын А/639 дугаар захирамжаар 2018 оны 5 дугаар сарын 20-ны дотор эргэн төлөгдөх нөхцөлөөр 100 сая төгрөгийг дүүргүүдэд аюулгүйг нөөц бүрдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр хуваарилав. Нийслэлийн хэмжээнд 8 дүүргийн 54 хорооны 4100 гаруй өрхийн 438 мянган толгой мал өвөлжих төлөвтэй байна. Энэ нь 2016 оноос 8.6 хувиар буюу 35</p>	100	<p>Нийслэлийн Засаг даргын А/639 дүгээр захирамж, 04 дүгээр албан даалгавар гарч дүүргүүдэд хүргүүлсэн байна.</p>

			мянган толгой малаар өссөн дүнтэй байна.		
	2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн заавал бэлтгэн бүрдүүлэх өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийн хэмжээг 2 дугаар хавсралт ёсоор баталсугай.	Өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийн тооцоог дүүрэг тус бүрээр гаргах .	<p>Нийслэлийн хэмжээнд 500тн өвс, 300 тн тэжээл аюулгүйн нөөцөд бэлтгэх тооцоог дүүрэг тус бүрээр гаргасан ба нөөцийн өвс, тэжээлийг өнөөдрийн үнэ, ханшаар тооцход 270 гаруй сая төгрөг шаардагатай байна.</p> <p>Нийслэлийн 2016 оны жилийн эцсийн мал тооллогоор 438 мянган толгой мал тоологдсон, бүх малыг малын төрөл, дүүрэг, тус бүрээр нь 1157 мянган хонин толгойгоор тооцож, аюулгүйн нөөцөд шаардагдах өвс, тэжээлийн тооцоог гаргасан. Энэ ажлын хүрээнд мал бүхий дүүргүүд дараах байдлаар аюулгүйн нөөцөө бүрдүүлэх арга хэмжээ авч ажилласан байна. Үүнд:</p> <p>Багануур дүүрэг: Засаг даргын нөөц хөрөнгөөс 6 сая төгрөг шийдвэрлүүлж үүнээс /1000 боодол / буюу 25 тн өвс “Наран цахиурт” ХХК-ны саравчинд хадгалсан байна.</p> <p>Багахангай дүүрэг: иргэд аж ахуй нэгжийн хандив тусламжаар 4.7 сая төгрөг төвлөрүүлсэн байна.</p> <p>Баянзүрх дүүрэг шаардлагатай нөхцөлд сар бүр засаг даргын нөөц хөрөнгөөс 20 сая төгрөг гаргахаар шийдвэрлэсэн. Налайх дүүрэг: 25 тн өвс, 5 тн тэжээл бэлтгэн 350 дугаар цэргийн ангийн ангорт засвар хийж, ариутган, мэрэгчээс хамгаалж хадгалсан байна.</p> <p>Сонгинохайрхан дүүрэг: Дүүргийн засаг даргын нөөцөөсөө 50 сая төгрөг шийдвэрлүүлэн эхний ээлжид 30 сая төгрөгөөр өвс худалдан авсан.</p> <p>Сүхбаатар дүүрэг: Засаг даргын нөөцөөсөө 6 сая төгрөгийг шийдвэрлэсэн байна.</p> <p>Хан-Уул дүүрэг : Дүүргийн засаг даргын нөөцөөсөө 50 сая төгрөг шийдвэрлүүлэн эхний ээлжид 30 сая</p>	100	Өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийн хэмжээг тооцон албан даалгавартай дүүргүүдэд хүргүүлсэн байна.

				төгрөгөөр өвс худалдан авсан байна. Нийслэлийн Засаг даргын А/639 дугаар захирамжаар 2018 оны 5 дугаар сарын 20-ны дотор эргэн төлөгдөх нөхцөлөөр 100 сая төгрөгийг дүүргүүдэд хуваарилав. Нийслэлийн Засаг даргын А/639 дугаар захирамжаар 2018 оны 5 дугаар сарын 20-ны дотор эргэн төлөгдөх нөхцөлөөр 100 сая төгрөгийг дүүргүүдэд хуваарилав.		
3. Өвөл, хаврын цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшиг тохиолдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай:						
	3.1. хөдөө аж ахуйн салбарын 2017 оны өвөлжилтийн бэлтгэл хангах нарийвчилсан төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр шуурхай шийдвэрлэж ажиллах;	2017 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах төлөвлөгөө боловсруулах.	Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах талаар Нийслэлийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 04 тоот 2 зүйл 8 заалттай албан даалгавар боловсруулан батлуулж мал бүхий дүүргүүдэд албан даалгаврыг хүргүүлсэн. Дүүрэг тус бүр өвөлжилтийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа.	100	Төлөвлөгөөний дагуу ажиллах.	
	3.2. өвөл, хаврын бэлчээрийн даацад тулгуурлан сум дундын болон аймаг дундын отрын бүс нутгууд, хилийн зурвас газар, байгалийн тусгай хамгаалалттай газарт отроор өвөлжих, хаваржих өрх, малын тоог тохирон холбогдох газруудтай зохих журмын дагуу гэрээ байгуулан хэрэгжүүлэх;	Холбогдох газруудтай хамтран ажиллах	Нийслэлийн 2016 оны малын тоонд үндэслэн отроор өвөлжих малын судалгааг дүүрэг бүрээр гарган ажиллалаа. Нийслэлийн хэмжээнд өөр аймаг сумдын нутагт 241 өрхийн 90 мянган толгой мал отроор өвөлжиж байна. Хэрлэнбаян-Улаан, Малахын аймаг дундын отрын нутгийн бэлчээр ашиглалтыг зохицуулах орон тооны бус зөвлөлийн хурал 2017 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Хэнтий аймгийн Дэлгэрхаан суманд зохион байгуулагдаж 2017-2018 онд Хэрлэнбаян-Улаан отрын тусгай хэрэгцээний нутагт Багануур дүүргийн 5 хорооны 30.000 мал өвөлжүүлэх квот авсан. Одоогийн байдлаар тус дүүргийн 30 гаруй өрхийн 28.000 гаруй мал отрын бүсэд байна. Удирдлагуудыг оролцуулан гэрээ байгуулан, малчин өрхүүдэд эмнэлэг болон бусад үйлчилгээг орон нутгаас үзүүлэх талаар	100	Дүүргүүдэд анхаарч ажиллах талаар чиглэл өгөгдөнө.	

			ажлын чиглэл өгсөн.		
	3.3. зарим шаардлагатай хадлангийн талбайг өнжөөх, сэлгэх, өөр аймгийн нутагт хадлан бэлтгэх гэрээ хийж зохицуулах;	Хадлан авах боломжтой аймгуудийн удирдлагад хүсэлт гаргах .	Нийслэлийн малчдын өвөлжилтийн бэлтгэл хангуулах зорилгоор Төв, Сэлэнгэ, Дорнод аймгийн засаг дарга нарт нийслэлийн засаг даргын 2017 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 02-02/27, 25 тоот хадлангийн газар хүссэн, албан бичиг хүргүүлээ. Нийслэлийн хэмжээнд хадлангийн талбай хомс байдгаас малчид өөр аймаг, сумдаас болон зах зээлээс өвс, тэжээлийг худалдан авч нөөцөлсөн байна. Малчдын төвшинд 902тн өвс, 200тн сүрэл 52.2 тн ногоон тэжээл, 4.75 тн үйлдвэрийн тэжээл, 29.5 тн гар тэжээл, давс хужир 34.9 тн бэлтгэсэн мэдээтэй байна. Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явцыг удирдлагууд болон холбогдох газарт тухай бүр тайлагнаж ажилласан. Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны Нарийн, Шар хадны хэсгийн малчин өрхүүд бүлэг болон нэгдэж ажиллах хүч техникээ дундын ашиглалтад зөв хуваарилан ашиглаж Сэлэнгэ, Сүхбаатар, Дорнод аймгаас 100тн хадлан, мөн Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны Засаг дарга Сэлэнгэ аймгийн Түшиг сум, Дорнод аймгийн Хөлөнбуйр сумдын засаг дарга нартай хэлэлцээр хийж 1000тн өвс хадлан бэлтгэж мал бүхий иргэдэд зах зээлийн ханшаас доогуур үнээр борлуулсан байна.	70	Хадлан бэлтгэх газар тодорхой болох
	3.4. малын гоц халдварт, халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг технологийн хугацаанд нь чанартай зохион байгуулж, мал эмнэлгийн дуудлага, үйлчилгээний бэлэн байдлыг бүрдүүлж, шуурхай удирдлагаар хангаж ажиллах;	Нийслэлийн засаг даргын А/143 тоот захирамжийн дагуу , Мал, амьтны гоц халдварт болон халдварт , өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд нийт 778.3 мал	Мал эмнэлгийн ажил үйлчилгээг графикийн дагуу гүйцэтгэж ажиллалаа. Малын хашаа хороо 585.41м, гахай шувууны байр 265.13м2, худаг, уст цэг 12.0м2, худалдааны төв 77.92м2, түүхий эд хадгалах цэг 66.72м2, албан газар 40.47м2, тэжээлийн агуулах 19.4м2, мал амьтны сэг зэм 28.3м2, тээврийн хэрэгсэл 248.5м2, боловсруулах үйлдвэр, нядалгааны	100	Малын гоц халдварт, халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлнэ.

			<p>Паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэхэд 742,4 толгой мал, Ариутгал халдваргүйжүүлэлтэд 16692.7 м2 талбай, тус тус хамруулахаар төлөвлөсөн.</p>	<p>газар 30.0м2, бэлчээрийн талбай 88.6м2, Сонгинохайрхан дүүргийн шүлхий өвчний голомтод 2012.3м2, Хан-Уул дүүргийн шүлхий өвчний голомт 580.5м2, Налайх дүүргийн цэцэг өвчний голомт 111.3м2 буюу нийтдээ 4385.4 мянган м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийгдсэн байна. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар: Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх зорилгоор Нийслэлийн мал эмнэлгийн газраас сэрэмжлүүлэг, анхааруулга гаргаж байгууллагын цахим хуудас, Нийслэлийн 9 дүүргийн 20 МЭҮҮН, хүнсний худалдааны төвийн дэргэдэх 23 МЭАЦЛ, мал нядалгааны газруудын 6 лабораториудад хүргүүлэн ажиллаж байна. Мөн радио, телевиз хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд 18 удаа ярилцлага, мэдээлэл өгч ажилласан. Мал эмнэлгийн дуудлага үйлчилгээний бэлэн байдлыг хангаж /Найман сая хоёр зуун наян таван мянган/ төгрөгийн үнэ бүхий 19 нэр төрлийн бараа материал худалдан авалт хийж нөөц бүрдүүллээ. Нийслэлийн 9 дүүргийн 20 МЭҮҮН-дэд мал эмнэлгийн бэлэн байдлыг хангах зорилгоор ариутгал халдваргүйтгэлийн бодис /ваймкон 70 кг, хлорын шохой 1100 кг, хайкоп 195 кг/ хуваарилан хүргэж ажиллаж байна. Нийслэлийн мал эмнэлгийн газрын нөөцөд ваймкон 125 кг, хлорын шохой 2000 кг, хайкоп 370 кг тус тус байна.</p>		
	3.5. агаарын хуурайшилт их байгаатай холбогдуулан зун, намрын отор хийх газар нутагт улсын болон орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр шинээр худаг гаргах ажлыг шуурхай зохион байгуулж, хадлангийн талбайг зөвхөн орон нутгийн өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх, говийн аймгуудад гэрээ, түрээсээр ашиглуулах;	Шинээр худаг гаргах ажлыг шуурхай зохион байгуулах	Нийслэлийн хэмжээнд орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр шинээр худаг гарах төсөв, ажил тусгагдаагүй боловч, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр Хан-Уул дүүрэгт 3, Баянзүрх дүүрэгт 3, малчдын санаачилагаар Налайх дүүрэгт 1 худаг	70	Өвөлжилтийн бэлтгэл хангахад нэн шаардлагатай	

				нийт 7 худаг шинээр гаргасан. Шинээр гаргах шаардлагатай худгийн судалгааг гарган санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэхээр санал боловсруулан ХХААХҮЯ, нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн.		
		3.6. бэлчээрийн хортон мэрэгч, шавьжтай тэмцэх ажилд улсын төсвийн хөрөнгөөс гадна орон нутгийн төсөв, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг зарцуулж, малчдын идэвх санаачилгыг өрнүүлэн удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг сайжруулах;	Хот орчмын тариалангийн болон бэлчээрийн талбайн хог ургамал, хортон шавьжтай тэмцэх талаар заавар, зөвлөгөө өгөх, хяналт шалгалт хийх	Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын 2017 оны 06 сарын 13-ны өдрийн удирдамжийн дагуу нийслэлийн 5 дүүргийн 220 гаруй га талбайгаар явж 234 иргэн, аж ахуйн нэгжид тариалангийн болон бэлчээрийн талбайн хог ургамал, хортон шавьжтай тэмцэх талаар заавар, зөвлөгөө өгч ажилласан. Хот орчмын бэлчээрийн талбайн хортон мэрэгч, шавьжтай тэмцэхэд улсын болон орон нутгийн төсөвт хөрөнгө тусгагдаагүй тул энэ чиглэлээр өөр томоохон ажил зохион байгуулагдаагүй.	30	Иргэн, аж ахуй нэгж мэдлэг мэдээлэлтэй болж ургац алдахгүй.
		3.7. малын хашаа, саравч, уст цэгээ засварлах, тохижуулах, түлш бэлтгэх, цаг агаар хүндэрсэн нөхцөлд хэрэглэх өвс, тэжээл, гар тэжээлийг нөөцлөх, өвлийн хувцас хэрэглэл, хоол хүнс базаах зэрэг мал өвөлжилтийн бэлтгэл ажлыг малчин өрх бүрээр сайтар хангуулах;	Төлөвлөгөө, албан даалгаварт тусган ажиллах	Мал бүхий дүүргийн, малыг хонин толгойд шилжүүлэн шаардлагатай өвс, тэжээлийн тооцоог гаргаж, аж ахуй нэгжүүд, малчид, фермер эрхлэгчид өөрсдийн нөөц боломжид тулгуурлан өвс, тэжээл бэлтгэн нөөцлөх, өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах талаар албан даалгаварт тусгалаа. Мал өвөлжилтийн бэлтгэл ажлыг малчин өрх бүрээр хангуулах, өрх бүрийн хувийн бэлтгэлийг сайтар хангуулах талаар Засаг даргын албан даалгаварт тодорхой тусган, ажлын чиглэл өгч ажилласан бөгөөд хашаа, саравч, уст цэгийг засварлах, тохижуулах, түлээ түлш бэлтгэх, цаг агаар хүндэрсэн нөхцөлд хэрэглэх өвс, тэжээл, гар тэжээлийг нөөцлөх, өвлийн хувцас хэрэглэл, хоол хүнсээ базаах зэрэг ажлуудын биелэлт хангагдсан байна. Малчдын төвшинд гар тэжээл бэлтгэх ажлын талаар зөвлөмж боловсруулж, мал бүхий 8 дүүрэгт хүргүүлж ажилласан.	100	Өвөлжилтийн бэлтгэл хангахад нэн шаардлагатай

		<p>3.8. ургац хураалтад ажиллах хүн хүч, техникийн бэлтгэл, зохион байгуулалтыг хангуулан цаг агаарын гамшигт үзэгдлээс ургацаа хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч ажиллах;</p>	<p>Иргэн, аж ахуй нэгжид урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж өгөх.</p>	<p>Нийслэлийн 5 дүүргийн 220 гаруй га талбайгаар явж 234 иргэн, аж ахуйн нэгжид цаг агаарын гамшигт үзэгдлээс ургацаа хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар заавар, зөвлөгөө өгч ажилласан. Бэлчээрийн менежментийг сайжруулах төслийн хүрээнд газар тариалангийн тоног төхөөрөмжийг нийлүүлж техникийн шинэчлэл хийж, үйл ажиллагаа явуулах бэлтгэл ажлыг хангаад байна. Мөн тэжээлийн болон хадлангийн тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй нөхцөлөөр фермийн аж ахуй эрхлэгчдэд олгох талаар санал боловсруулж “Мал хамгаалах сан”-д хүргүүлэн ажилласан. Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны Нарийн, Шар хадны хэсгийн малчин өрхүүд бүлэг болон нэгдэж ажиллах хүч техникээ дундын ашиглалтад зөв хуваарилан ашиглаж Сэлэнгэ, Сүхбаатар, Дорнод аймгаас 100тн хадлан, мөн Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны Засаг дарга Сэлэнгэ аймгийн Түшиг сум, Дорнод аймгийн Хөлөнбуйр сумдын засаг дарга нартай хэлэлцээр хийж 1000тн өвс хадлан бэлтгэж мал бүхий иргэдэд зах зээлийн ханшнаас доогуур үнээр борлуулсан байна.</p>	<p>100</p>	<p>Иргэн, аж ахуй нэгж мэдлэг мэдээлэлтэй болж ургац алдахгүй.</p>
		<p>3.9. аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдал, нөөц бүрдүүлэх зорилгоор шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, түргэн тусламжийн машин, багаж хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлэх;</p>	<p>1.Эмнэлэг албадыг чадавхижуулах сургалтад хамруулах явуулах 2.Жил бүр нийслэлийн эмнэлэг албад иж бүрэн үзүүлэх сургууль, НЗДаргын нэрэмжит үзлэгт хамрагдах /жил бүр 4-5 байгууллаг орно/</p>	<p>Дэлхий зөн Монгол ОУБ-ын Гамшигт тэсвэртэй Улаанбаатар төслийн хүрээнд НЭМГ болон харьяа байгууллагаас 15 сургагч багш бэлтгэсэн. ”Гамшигт тэсвэртэй Улаанбаатар“ төслийн хүрээнд Дэлхийн Зөн Олон улсын байгууллага, Нийслэлийн Онцгой байдлын газартай хамтран 2017 онд 01 сар, 07 сард 2 удаа сургалтыг зохион байгуулж, НЭМГазар, харьяа 26 байгууллагын 68 хүн хамрагдлаа. НЗД-ын 2017 оны А/11 дүгээр захирамжийн хэрэгжилтийн хүрээнд Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт</p>	<p>100</p>	<p>НЭМГ болон харьяа ЭМБ-ын эмнэлэг албадын бэлэн байдал хангагдсан.</p>

				дүүрэгт гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль явагдсан бөгөөд ЧЭМТ, СБНЭ, СБЭМТ амжилттай оролцож, НЗДаргын өргөмжлөлөөр шагнагдсан. БЗДүүрэг, Багануур дүүргүүд Засаг даргын нэрэмжит үзлэгт хамрагдсан.		
	3.10. нутагтаа болон отроор өвөлжиж, хаваржиж байгаа малчдын судалгаанд үндэслэн эрүүл мэндийн явуулын үйлчилгээг үзүүлэх хуваарь гарган аймаг, сумын эмнэлгийн бэлэн байдлыг хангуулах.	ӨЭМТөвүүдэд явуулын тусламж, үйлчилгээ үзүүлэх	“Явуулын тусламж, үйлчилгээ” үзүүлэх төслийг Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн алслагдсан 2 хороон дээр 2017 оны 06 сарын 05-ны өдрөөс үйл ажиллагааг эхэлсэн. Чингэлтэй дүүргийн 19 хорооны тайлан: ӨЭМТ-н амбулаториор 100, гэрээр-62 хүнд /хөгжлийн бэрхшээлтэй, хэвтрийн, зусланд амьдардаг өндөр настан/ холестрин, цусанд сахар үзэх, В, С вирусн илрүүлэг хийсэн. Хеликобактерийг 51 хүнд, бэлгийн замын халдварыг 15 хүнд илрүүлж, эерэг гарсан тул ЧЭМТөвийн поликлиникт илгээж, шинээр илэрсэн 3 тэмбүүтэй хүнийг эмчилгээнд хамруулсан. Мөн цөсний чулуутай 2 хүнийг мэс заслын эмч рүү илгээсэн ба умайн хавдар 1, бөөрний кистатай -3 хүнийг тус тус лавлагаа төв рүү илгээсэн. Багахангай дүүргийн ЗДТГ-аас өөрийн дүүргийн болон өөр аймаг сумын нутагт отроор намаржиж өвөлжиж байгаа малчин өрхүүдээрээ нэг цонхний үйлчилгээг эрүүл мэндийн төв, хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс албатуудтайгаа сар бүр зохион байгуулан ажилласан байна. Багануур дүүргийн 5 хорооны 30.000 мал өвөлжүүлэх квот авсан. Одоогийн байдлаар тус дүүргийн 30 гаруй өрхийн 28.000 гаруй мал отрын бүсэд орсон байна. Удирдлагуудыг оролцуулан гэрээ байгуулан, малчин өрхүүдэд эмнэлэг болон бусад үйлчилгээг орон нутгаас үзүүлэх талаар ажлын чиглэл өгч ажиллалаа.	100	Эмнэлгийн бэлэн байдлыг хангана.	
ДУНДАЖ ХЭРЭГЖИЛТ					80.8	

5	<p>“Жимс жимсгэнэ” үндэсний хөтөлбөр батлах тухай</p> <p>2017.08 .09</p> <p>№223</p>	<p>3.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг жил бүрийн эдийн засаг,нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж,шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөв,гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, аймаг нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.</p>	<p>Нийслэлийн эдийн засаг,нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд “Жимс, жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийн дэд хөтөлбөрийг боловсруулахаар санал өгөх.</p>	<p>Нийслэлийн эдийн засаг,нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд “Жимс, жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийн дэд хөтөлбөрийг боловсруулахаар санал өгсөн. Мөн байгууллагын 2018 онд хийх ажлын төлөвлөгөөнд тухайн чиглэлээр тусгасан.</p>	0	Хугацаа болоогүй	<p>нийслэлийн хэмжээнд жимс, жимсгэний талбай 50 га - аар нэмэгдэнэ.</p>
		<p>4.Жимс, жимсгэнэ хөтөлбөрийг орон нутгийн хөрс,цаг уурын онцлогт тохируулан улсын хэмжээнд хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллан, үр дүнг жил бүрийн 2 дугаар сарын 10-ны дотор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд тайлагнаж байхыг холбогдох сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>	<p>Нийслэлийн 9 дүүргийн хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн нарт “Жимс, жимсгэнэ” хөтөлбөрийг бүрэн файлаар нь хүргүүлнэ. ХААИСургуулийн Агроэкологийн сургуулийн профессорын багтай уулзах санал солилцох,</p>	<p>Нийслэлийн 9 дүүргийн хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн нарт “Жимс, жимсгэнэ” хөтөлбөрийг бүрэн файлаар нь хүргүүлсэн. ХААИСургуулийн Агроэкологийн сургуулийн профессорын багтай уулзаж, нийслэл хотын хөрс,цаг уурын онцлогт тохирох хөх далан хальс жимсгэний тариалалт, соортын онцлог, үржүүлгийн талаар санал солилцсон.</p>	0	Хугацаа болоогүй	<p>Таримал жимс жимсгэний нэр төрөл нэмэгдэх, тэдгээрийг хэрэглэх хэрэглээ болон хүн ам аюулгүй экологийн цэвэр жимс жимсгэнийг хүнсэндээ тогтвортой хэрэглэж хэвшинэ.</p>
6	<p>“Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөр батлах тухай</p> <p>2017.09.22</p> <p>№278</p>	<p>1.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, түүнд шаардагдах хөрөнгийн их үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулан санхүүжүүлэх арга хэмжээг авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын үүрэг гүйцэтгэгч П.Сэргэлэн, Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Б.Чойжилсүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.</p>	<p>Нийслэлийн эдийн засаг,нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж орон нутгийн төсөвт санал өгнө. Байгууллагын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн дагуу хийх ажлын төлөвлөгөө боловсруулна.</p>	<p>“Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Хүнсний ногоо” дэд хөтөлбөрийг боловсруулахаар судалж байна.</p>	0	Хугацаа болоогүй	<p>хүнсний ногооны үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын хэрэгцээгээ жилийн турш тогтвортой хангана.</p>

	2."Хүнсний ногоо" үндэсний хөтөлбөрийг орон нутгийн хөрс, уур амьсгалын онцлогт тохируулан хэрэгжүүлж, үр дүнг жил бүрийн 2 дугаар сарын 10-ны дотор Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнаж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд "Хүнсний ногоо" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулна. Мэдээг тайланг хугацаанд нь хүргүүлж ажиллах.	Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэхээр танилцуулах сургалт зохион байгуулахаар байгууллагын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгахаар ажиллаж байна.	0 Хугацаа болоогүй	Нийслэлийн хүн амыг шинэ ургацын ногоогоор тогтвортой хангана.	
ДУНДАЖ ХЭРЭГЖИЛТ					0	

Биелсэн:2

Хэрэгжих шатанд:1

Хугацаа болоогүй:2

Тасарсан:0

Үнэлгээгүй ажил:1